

# Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/2/СТА-ТЗШ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Чойр хот 2022 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас:70543156 Цахим хаяг: <a href="mailto:Saranmuyab@audit.gov.mn">Saranmuyab@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Утас:70543179 Цахим хаяг: <a href="mailto:Naranbayarg@audit.gov.mn">Naranbayarg@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Ц.Батсайхан Утас: 70543179 Цахим хаяг: <a href="mailto:Batsaikhants@audit.gov.mn">Batsaikhants@audit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	12
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт .....	13
4.1 Залруулсан алдаа.....	13
4.2 Төлбөрийн акт тогтоогдоогүй.....	13
4.3 Албан шаардлага өгөгдөөгүй.....	13
4.4 Зөвлөмж .....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГСА	Говьсүмбэр аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: govisumber@audit.gov.mn

*2022.02.24 № 11*

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн "Халамжийн сан"-гийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн "Халамжийн сан"-гийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

4208020034

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
.	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ [2]+[3]	143704.41	2,276,670.00
3102	Банкинд байгаа бэлэн мөнгө/төгрөг/ [4]+[5]	143704.41	2,276,670.00
3.1.4.1	Банкинд байгаа бэлэн мөнгө/ОНТөсөв/	143704.41	2,276,670.00
33	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН [1]+[6]	143704.41	2,276,670.00
.	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН [13]+[14]	143704.41	2,276,670.00
510301	Өмнөх үеийн үр дүн	0	143,704.41
5103020002	Тайлант үеийн үр дүн орон нутаг	143704.41	2,132,965.59
0	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН [30]+[31]+[32]+[33]	143704.41	2,276,670.00
0	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН [29]+[34]	143704.41	2,276,670.00

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1303	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,966,139,500.00	804,733,112.94
130301	Улсын төсвийн санхүүжилтийн орлого	1,930,900,500.00	769,490,000.00
130302	Орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлого	35,239,000.00	35,239,000.00
14	Бараа, үйлчилгээний орлого [5]+[6]+[7]+[8]	1,604,431.08	0.00
1401011	Улсын төсвийн хүүгийн орлого	1,109,935.61	4,112.94
1401012	Улсын төсвийн бусад орлого	243,098.40	0.00
1401021	Орон нутгийн төсвийн хүүгийн орлого	251,397.07	0.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН [1]+[4]	1,967,743,931.08	804,733,112.94
2603	Төсөвт төвлөрүүлэх [16]+[17]	43,570,387.78	18,913,022.45
260301	Төсөвт төвлөрүүлэх улсын төсөв	41,732,490.60	7,994,022.45
260302	Төсөвт төвлөрүүлэх орон нутгийн төсөв	1,837,897.18	10,919,000.00
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ [19]-с [39]-р мөр	1,923,081,089.00	783,687,124.90
2701010101	Халамжийн тэтгэврийн сангийн зарцуулалт	741,152,310.00	178,271,850.00
2701010102	Халамжийн тэтгэмжийн сангийн зарцуулалт	273,758,810.00	222,637,500.00
2701010103	Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт	197,742,290.00	188,829,050.00

Говьсүимбэр аймгийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2701021300	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт	16,800,000.00	0
2701010900	Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	94,734,500.00	57,667,300.00
2701021505	Бусад хөнгөлөлт, тэтгэмжийн зардал	0	0
2701010105	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	53,029,780.00	43,509,890.00
2701010104	Жирэмсэн нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт	5,989,320.00	0.00
2701023000	ОНО Түшиглэсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт	16,852,500.00	11,120,000.00
2701010106	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	147,526,525.00	78,222,411.90
2702010101	Алдарт эхийн одонгийн мөнгөний зарцуулалт	162,300,000.00	0.00
27020102	Ахмад дайчид алдар цолтон ахмад настанд олгох тэтгэмж хөнгөлөлт	15,010,000.00	0.00
2702010400	Насны хишиг	112,980,000.00	0.00
2701010700	Цалинтай ээж хөтөлбөрийн зардал	39,964,020.00	0.00
2701010800	Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөрийн зардал	41,268,750.00	0.00
2701010108	Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал	3,972,284.00	3,165,973.00
.	Банкны шимтгэл [	948,750.00	263,150.00
.	Банкны шимтгэл	948,750.00	263,150.00
2702010311	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн банкны шимтгэл	948,750.00	263,150.00
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН [10]+[15]+[18]+[40]	1,967,600,226.78	783,687,124.90
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН [9]-[50]	143,704.30	2,132,965.59

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээн ий нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 01 сарын 1-ээрх үлдэгдэл			0.11	0.11
2	2020 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл			143,704.41	143,704.41
3	Тайлант үеийн үр дүн			2,132,965.59	2,132,965.59
4	2021 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл			2,276,670.00	2,276,670.00

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Говьсүимбэр аймгийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1303	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,966,139,500.00	804,729,000.00
130301	Улсын төсвийн санхүүжилтийн орлого	1,930,900,500.00	769,490,000.00
130302	Орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлого	35,239,000.00	35,239,000.00
1401	Бараа, үйлчилгээний орлого [5]+[6]+[7]+[8]+[9]+[10]	1,851,491.08	3,423,537.04
1401011	Улсын төсвийн хүүгийн орлого	1,109,935.61	4,112.94
1401012	Улсын төсвийн бусад орлого	243,098.40	0
1401021	Орон нутгийн төсвийн хүүгийн орлого	251,397.07	0
1401013	Улсын төсвийн буцаасан орлого	247,060.00	3,419,424.10
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ТӨВ [1]+[4]	1,967,990,991.08	808,152,537.04
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ	1,923,328,149.00	786,843,399.00
2701021100	Халамжийн тэтгэврийн сангийн зарцуулалт	741,169,410.00	178,271,850.00
2701021200	Халамжийн тэтгэмжийн сангийн зарцуулалт	273,764,100.00	223,199,020.00
2701010103	Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт	197,742,290.00	175,629,050.00
2701021300	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт	16,800,000.00	13,200,000.00
2701021500	Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	94,884,500.00	57,667,300.00
2701021604	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	53,029,780.00	43,537,890.00
2701022000	Жирэмсэн нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт	5,989,320.00	0
2701023000	ОНО Түшиглэсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт	16,852,500.00	11,120,000.00
2701024000	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	147,526,525.00	81,052,316.00
2702010101	Алдарт эхийн одонгийн мөнгөний зарцуулалт	162,300,000.00	0
27020102	Ахмад дайчид алдар цолтон ахмад настанд олгох тэтгэмж хөнгөлөлт	15,010,000.00	0
2702010400	Насны хишгийн зардал	112,980,000.00	0
2701010700	Цалинтай ээж хөтөлбөрийн зардал	39,964,020.00	0
2701010800	Өрх толгойлсон эх,эцэг хөтөлбөрийн зардал	41,343,420.00	0
2702020308	Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал	3,972,284.00	3,165,973.00
.	Банкны шимтгэл [40]+[44]	948,750.00	263,150.00
.	Банкны шимтгэл УТ [41]+[42]+[43]	948,750.00	263,150.00
2702010311	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн банкны шимтгэл	948,750.00	263,150.00
2603	Төсөвт төвлөрүүлэх [53]+[55]	43,570,387.78	18,913,022.45
260301	Төсөвт төвлөрүүлэх улсын төсөв	41,732,490.60	7,994,022.45
260302	Төсөвт төвлөрүүлэх орон нутгийн төсөв	1,837,897.18	10,919,000.00

	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН [12]+[17]+[39]+[49]+[52]+[61]-[62]+[63]- [64]	1,967,847,286.78	806,019,571.45
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ [11]-[56]	143,704.30	2,132,965.59
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ [60]- [59]	143,704.30	2,132,965.59
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.11	143,704.41
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	143,704.41	2,276,670.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/д	Сангийн орлого	Төлөвлөгөө	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	0	143,704.41	-143704.41
2	Сангийн үйл ажиллагааны зардал	804,729,000.00	783,687,124.90	21,041,875.10
3	АДЗ-ийн гишүүдийн урамшуулал	3,700,000.00	3,165,973.00	534,027.00
4	Олон нийтийн оролцоонд түншилсэн халамжийн үйлчилгээ	11,239,000.00	11,120,000.00	119,000.00
5	Банкны шимтгэл	900,000.00	263,150.00	636,850.00
6	Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтийн зардал	59,000,000.00	57,667,300.00	1,332,700.00
7	Халамжийн тэтгэврийн сангийн зарцуулалт	179,000,000.00	178,271,850.00	728,150.00
8	Халамжийн тэтгэмжийн сангийн зарцуулалт	225,000,000.00	222,637,500.00	2,362,500.00
9	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт	177,000,000.00	175,629,050.00	1,370,950.00
10	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт Орон нутаг	24,000,000.00	13,200,000.00	10,800,000.00
11	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	45,000,000.00	43,509,890.00	1,490,110.00
12	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	79,890,000.00	78,222,411.90	1,667,588.10
13	УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ	769,490,000.00	769,490,000.00	0.00
14	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ	35,239,000.00	35,239,000.00	0.00
15	Тохируулгын дүн	0	-18,908,909.51	18,908,909.51
16	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	0	2,276,670.00	-2,276,670.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу аймгийн Халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайлангаар шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөөгүй болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/41 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

“Халамжийн сан”-гийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний төрөл, хамрах хүрээг тогтоох, нийгмийн халамжийн сан бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг зарцуулах, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулж ажиллаж байна.

Тайлант онд тус зорилтын хүрээнд 4 зорилт, 19 арга хэмжээг хэрэгжүүлж 97.7 хувийн биелэлтэй ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудитор нь тайлант онд тус газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Халамжийн сан нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн зардлын 1,967,600.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 19,676.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувиар буюу 15,740.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн Халамжийн сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,133.0 мянган төгрөгөөр буюу 1,484.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	143.7	2,276.7	2,133.0
Авлага			0.0
Урьдчилгаа			0.0
Бараа материал			0.0
Үндсэн хөрөнгө			0.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>143.7</b>	<b>2,276.7</b>	<b>2,133.0</b>
Өр төлбөр			0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	143.7	2,276.7	2,133.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>143.7</b>	<b>2,276.7</b>	<b>2,133.0</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,276.7 мянган төгрөг болж 2,133.0 мянган төгрөгөөр өссөн нь оны эцэст арилжааны банкны данснууд үлдэгдэлтэй гарсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,276.7 мянган төгрөг болж 2,133.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгээр нэмэгдсэн байна.

Аймгийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,163,010.8 мянган төгрөгөөр буюу 59.1 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс санхүүжилтийн орлого 1,161,410.5 мянга, бараа үйлчилгээний орлого 1,600.3 мянган төгрөгөөр тус тус буурч материаллаг өөрчлөлт гарсан байна.

Нийт зардал өмнөх оноос 1,183,913.1 мянган төгрөгөөр буюу 60.1 хувиар буурсан байна. Энэ нь өмнөх оны үзүүлэлтээс төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардал буурсан байна.

Энэ нь тайлант онд халамжийн нэгдсэн системд холбогдож тэтгэвэр тэтгэмжүүдийг улсын төсвөөс олгосноос санхүүжилт буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүн рүү нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус сангийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,037,203.7 мянга, нийт зарлагыг 3,037,203.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,553,39.7 мянган төгрөгөөр бууруулж, 1,483,864.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Анх 1,483,864.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан боловч төсвийн тодотголоор нийгмийн халамжийн тэтгэврийн тэтгэмжийг 559,000.0 мянга, асаргааны тэтгэмжийг 50,500.0 мянга, амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмжийг 21,000.0 мянга, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх хөнгөлөлтийг 3,000.0 мянга, ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлтийг 62,164.0 мянга, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зардлыг 16,110.0 мянга, банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамжийг 2,700.0 мянга нийт 714,474.0 мянган төгрөгөөр бууруулж, амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийн ажлын хөлсийг 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 769,490.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “71902-нийгмийн халамж” 1 хөтөлбөрийн хүрээнд 80801, үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр 769,490.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 769,490.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 769,490.0 мянга, орон нутгийн төсвөөс 35,239.0 мянга, нийт 804,729.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардалд 783,424.0 мянга, банкны шимтгэлийн зардалд 263.1 мянга нийт 783,687.1 мянган төгрөгийг зарцуулж, 10,919.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт 7,990.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, 2,132.9 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 783,687.1 мянган төгрөг буюу 97.3 хувьтай байгаа нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайланд улсын төсвөөс санхүүжилт 769,490.0 мянга, орон нутгийн төсвөөс 35,239.0 мянга, хүүгийн орлого 4.1 мянга, нийт 804,733.1 мянган төгрөгийн санхүүжилт, орлогыг тайлагнасан байна.

Мөнгөн гүйлгээний тайланд улсын төсвөөс санхүүжилт 769,490.0 мянга, орон нутгийн төсвөөс 35,239.0 мянга, хүүгийн орлого 4.1 мянга, улсын төсвийн буцаасан орлого 3,419.4 мянга, нийт 808,152.5 мянган төгрөгийн санхүүжилт, орлогыг тайлагнасан байна.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар тайлант онд гүйлгээ гараагүй байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцлон үзсэн боловч зөрчил илрээгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тухайн байгууллагад онцлох асуудал байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Говьсүмбэр аймгийн “Халамжийн сан” нь 2021 онд нийт 779,557.0 мянган төгрөгийн 49 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь үнэн зөв, бүрэн мэдээлсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тус газрын өмнөх оны санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн тул зөвлөмж өгөгдөөгүй болно.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Аймгийн Халамжийн сангийн үйл ажиллагаанд анхаарал татахуйц асуудал байхгүй байна

### **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар зөрчил илрээгүй

#### **4.1 Залруулсан алдаа байхгүй**

#### **4.2 Төлбөрийн акт тогтоогдоогүй**

#### **4.3 Албан шаардлага өгөгдөөгүй**

#### **4.4 Зөвлөмж өгөгдөөгүй**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/ мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн халамжийн сан	0	0	0	0	0	0	0	0	0	0